БИЗКОН АУДИТ

# АУДИТЫН ТАЙЛАН

## “ЦЕНТРАЛ ФИНАНС” ББСБ ХХК

**2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон**
**Санхүүгийн Тайлан**
**Хараат Бус Аудиторын Тайлангийн Хамт**

**УЛААНБААТАР**
**2023 он**

2023 он 03 сар 25 өдөр Дугаар СТА – 24/23 Улаанбаатар хот

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**“Централ финанс ББСБ” ХХК -ийн удирдлагад**

**Санхүүгийн Тайлангийн Аудитын Талаарх Тайлан**

***Дүгнэлт***

Бид “Централ финанс ББСБ” ХХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний сонгосон түүвэр, материаллаг байдлын түвшинд эс тооцвол “Централ финанс ББСБ” ХХК -ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн тайлант хугацааны санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулагдсан байна.

***Дүгнэлтийн үндэслэл***

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт ( АОУС )-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба НБЁЗОУСЗ-ийн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

***Аудитын гол асуудлууд***

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

***Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага***

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

***Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага***

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС–ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шүүмж ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн нөлөөтэй асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үзэж аудиторын тайландаа тодорхойлдог.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Л. ОТГОНБАЯР

БИЗКОН АУДИТ ХХК
BIZCON AUDIT LLC
УЛААНБААТАР ХОТ
ТТГ4917 Д. 2704404

**"ЦЕНТРАЛ ФИНАНС ББСБ" ХХК**
**ҮЛДЭГДЛИЙН ТЭНЦЭЛ**
**2022 оны 12 сарын 31**

(төгрөгөөр)

| Үзүүлэлт | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| ХӨРӨНГӨ | | |
| **Мөнгөн хөрөнгө** | **4,525,255.19** | **2,300,981.19** |
| Бэлэн мөнгө | 129,345.00 | |
| Банкинд байршуулсан харилцах | 4,395,910.19 | 2,300,981.19 |
| **Зээл /цэврээр/** | **230,585,153.80** | **286,860,930.44** |
| Нийт зээл /төгрөгөөр/ | **230,585,153.80** | **286,860,930.44** |
| Хэвийн зээл | 230,585,153.80 | 286,860,930.44 |
| Хугацаа хэтэрсэн зээл | | |
| **Чанаргүй зээл** | | |
| Хэвийн бус зээл | | |
| Эргэлзээтэй зээл | | |
| Муу зээл | | |
| (Зээлийн эрсдэлийн сан) | | |
| Бусад авлага | 3,692,672.99 | 4,863,882.52 |
| Урьдчилж төлсөн зардал,тооцоо | | |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **238,803,081.98** | **294,025,794.15** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | | |
| Эд хогшил | | |
| Хуримтлагдсан элэгдэл | | |
| Техник хэрэгсэл | 539,000.00 | 539,000.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | 44,917.01 | 224,595.23 |
| Биет бус хөрөнгө | | |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | | |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **494,082.99** | **314,404.77** |
| НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | **239,297,164.97** | **294,340,198.92** |
| ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР | | |
| **Богино хугацаат өглөг** | | |
| Цалингийн өглөг | | |
| ЭМД, НДШ өглөг | | |
| ХХОАТ өглөг | | 136,875.00 |
| ОАТ өглөг | 334,727.10 | 552,408.86 |
| Бусад өглөг | | |
| Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл | | |
| Итгэлцлийн үйлчилгээний өглөг | | |
| **Богино хугацаат өглөгийн дүн** | **334,727.10** | **689,283.86** |
| **Урт хугацаат өглөг** | | |
| Урт хугацаат зээл | | - |
| **Урт хугацаат өглөгийн дүн** | - | - |
| **Нийт өр төлбөрийн дүн** | **334,727.10** | **689,283.86** |
| **Эзэмшигчийн өмч** | | |
| Хувийн өмч | 200,000,000.00 | 200,000,000.00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | | |
| Хуримтлагдсан ашиг/алдагдал | 38,962,437.87 | 93,650,915.06 |
| **Эзэмшигчдийн өмчийн дүн** | **238,962,437.87** | **293,650,915.06** |
| **НИЙТ ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | **239,297,164.97** | **294,340,198.92** |

1 ВИЗИОН АУДИТ

**"ЦЕНТРАЛ ФИНАНС ББСБ" ХХК**
**ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**
**2022 оны 12 сарын 31** **( төгрөгөөр)**

| ҮЗҮҮЛЭЛТ | 2021 оны 12-р сарын 31 | 2022 оны 12-р сарын 31 |
|---|---|---|
| **Хүүгийн орлого** | 45,966,612.80 | 101,622,186.05 |
| Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого | | |
| Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого | 45,966,612.80 | 101,622,186.05 |
| Харилцах дансны хүүгийн орлого | | |
| Банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого | 2,972,728.62 | |
| Хүүгийн орлогын буцаалт | | |
| **Хүүгийн зардал** | | |
| Банкны байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | | |
| Бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал | | |
| **Цэвэр хүүгийн орлого** | 45,966,612.80 | 101,622,186.05 |
| **Хүүгийн бус орлого** | 5,503.56 | - |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | 5,503.56 | |
| Бусад үйлчилгээ | | |
| **Хүүгийн бус зардал** | 9,577,840.01 | 46,325,800.00 |
| Үндсэн болон нэмэгдэл цалин | 5,400,000.00 | 10,800,000.00 |
| Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын зардал | 669,600.00 | 1,419,100.00 |
| Сургалтын зардал | | 400,000.00 |
| Бусад зардал | | |
| Гэрээгээр ажиллагсдын ажлын хөлс | | 650,000.00 |
| Аудитын төлбөр | | 400,000.00 |
| Түрээсийн зардал | | 30,810,000.00 |
| Ашиглалтын зардал | | |
| Элэгдэлийн зардал | | 179,600.00 |
| Хөдөлмөр хамгаалал, галын аюулаас хамгаалах зардал | | |
| Харилцаа холбоо, интернет | 323,400.00 | 650,100.00 |
| Шатахуун болон тээврийн зардал | | |
| Сэлбэг хэрэгсэл засварын зардал | 2,536,355.00 | |
| Зохицуулалтын хураамжын зардал | | 640,000.00 |
| Захиалгат хэвлэлийн зардал | | |
| Автоматжуулалттай холбоотой урсгал зардал | | |
| Зар сурталчилгааны зардал | | 30,000.00 |
| Ариун цэвэрийн зардал | | |
| Бичиг хэргийн зардал | | 47,000.00 |
| Бусад зардал | 648,485.01 | 300,000.00 |
| **Цэвэр хүүгийн бус орлого/зардлын дүн** | (9,577,840.01) | (46,325,800.00) |
| **Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг алдагдал** | 39,355,997.85 | 55,296,386.05 |
| **Болзошгүй эрсдэлийн зардал** | | |
| **Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал** | 39,355,997.85 | 55,296,386.05 |
| **Зочин төлөөглөгчийн зардал** | | 55,500.00 |
| **Үйл ажиллагааны бус орлого** | | |
| **Үйл ажиллагааны бус зардал** | | |
| **Ердийн үйл ажиллагааны ашиг алдагдал** | 39,355,997.85 | 55,240,886.05 |
| **Баяр ёслол** | | |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал** | | |
| Орлогын татварын зардал | 393,559.98 | 552,408.86 |
| **Цэвэр ашиг/ алдагдал** | 38,962,437.87 | 54,688,477.19 |

ВИЗИОН АУДИТ

**"ЦЕНТРАЛ ФИНАНС ББСБ" ХХК**

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

**2022 оны 12 сарын 31**

**( төгрөгөөр)**

| ҮЗҮҮЛЭЛТ | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 2021 оны 12-р сарын 31 | 200,000,000.00 | - | 38,962,437.87 | 238,962,437.87 |
| НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | - |
| Тайлангийн хугацааны ашиг (алдагдал) | - | | 54,688,477.19 | 54,688,477.19 |
| Хувьцаат капиталын өсөлт | | | | |
| 2022 оны 12-р сарын 31 | 200,000,000.00 | - | 93,650,915.06 | 293,650,915.06 |



ВИЗКОН АУДИТ

"ЦЕНТРАЛ ФИНАНС ББСБ" ХХК

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2022 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

| ҮЗҮҮЛЭЛТ | | Дүн |
|---|---|---|
| **1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | - | **(2,168,774.00)** |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого** | - | **101,622,186.00** |
| Зээлийн хүүгийн орлого | | 101,622,186.00 |
| Үнэт цаасны хүүгийн орлого | | |
| Харилцах дансны хүүгийн орлого | | |
| Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого | | |
| Бусад үйлчилгээний орлого | | |
| **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага** | - | **103,790,960.00** |
| Үндсэн ба нэмэгдэл цалин | | 11,450,000.00 |
| Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал | | 1,419,100.00 |
| Ашиглалтын зардалд төлсөн мөнгө | | |
| Шатахуун холбоо, интернэт сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө | | 650,100.00 |
| Бичиг хэрэг, ариун цэврийн зардал | | |
| Татвар даатгалын байгууллагад төлсөн мөнгө | | 3,713,400.00 |
| Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан зардал | | |
| Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбогдоно гарах мөнгө | | |
| Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө | | 400,000.00 |
| Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө | | 640,000.00 |
| Бэлтгэн нийлүүлэгчид төлсөн мөнгө | | |
| Бусад үйлчилгээнд төлсөн мөнгө | | 85,518,360.00 |
| **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | - | **(2,168,774.00)** |
| **2. Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| **Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого** | - | **-** |
| Бусад мөнгөн орлого | | |
| **Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зарлага** | - | **55,500.00** |
| Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал | | 55,500.00 |
| Бусад зардал | | |
| **Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | - | **(55,500.00)** |
| **4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(2,224,274.00)** |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **4,525,255.19** |
| **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **2,300,981.19** |

Аудиторын туслах: Б.Дэлгэрмаа

Хүлээн зөвшөөрсөн



